

**АГААРЫН ХӨЛГИЙН МЕТАЛ ЭД АНГИД СОРИЛТЫН
ШИНЖИЛГЭЭ ХИЙЖ, ҮР ДҮНГ ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРЧ,
БАТАЛГААЖУУЛАХ ТАЛААР ХАМТРАН АЖИЛЛАХ
САНАМЖ БИЧИГ**

2025 оны 11 дугаар сарын 05-ны өдөр

Улаанбаатр хот

Нэг.Санамж бичгийн үндэслэл

Агаарын хөлгийн металаар хийгдсэн эд ангид сорилтын шинжилгээ хийлгэж байхаар нэг талаас Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах алба (цаашид Алба гэнэ)-ыг төлөөлж Албаны дарга Ж.Цолмон, нөгөө талаас ШУТИС-ийн МИТС-ийн Металын сорилт, туршилт эрдэм шинжилгээний төвийн захирал Ц.Мөнхтуяа нар тохиролцож энэхүү санамж бичгийг байгуулав.

Хоёр. Хоёр тал доорхи асуудлаар тохиролцов

- 2.1. Агаарын хөлгийн металаар хийгдсэн эд ангийн бат бөх чанарыг тодорхойлох сорилтын шинжилгээ хийх шаардлага гарсан үед хоёр тал хамтарч нөөц бололцоогоо дайчлан ажиллана.
- 2.2. Хоёр тал сорилтын шинжилгээг гүйцэтгэгч байгууллагын итгэмжлэлийн хүрээнд төлөвлөж, урьдчилан тохиролцсоны үндсэн дээр “Санамж бичиг” байгуулах замаар гүйцэтгэнэ.
- 2.3. Агаарын хөлгийн металаар хийгдсэн эд ангийн бат бөх чанарыг тодорхойлох сорилтын шинжилгээ хийх хамтын ажиллагаа нь тал бүрийн харилцан итгэлцэл, хууль ёсны үүрэгт захирагдах ёстойг хүлээн зөвшөөрнө.
- 2.4. Сорилтын шинжилгээг гардан гүйцэтгэгч нь лабораторын шинжилгээний үр дүнгийн нууцлалыг хадгална.
- 2.5. Сорилтын шинжилгээний үр дүнг Алба тайландаа нотлох баримт болгон ашиглана.

Гурав. Санамж бичгийн хүчинтэй хугацаа, түүнд оруулах өөрчлөлт

- 3.1. Энэхүү санамж бичиг нь гарын үсэг зурсан өдрөөс гурван жилийн хугацаанд хүчинтэй.
- 3.2. Талууд энэхүү санамж бичигт харилцан зөвшөөрсөний үндсэн дээр нэмэлт өөрчлөлт, шинэчлэлт хийнэ.

Энэхүү санамж бичгийг 2025 оны 11 сарын 05-ны өдөр Улаанбаатар хотноо 2 хувь үйлдэж гарын үсэг зурж баталгаажууллаа.

АГААРЫН ХӨЛГИЙН ОСОЛ, ЗӨРЧЛИЙГ
ШИНЖЛЭН ШАЛГАХ АЛБАНЫ ДАРГА
Ж.ЦОЛМОН
/...
8112738 ШИТЖ1492 9025011078

ШИНЖЛЭХ УХААН
ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛЬ
ШУТИС-ИЙН МИТС-ИЙН ӨМНӨӨС
МСТЭШТ-ИЙН ЗАХИРАЛ Ц.МӨНХТУЯА
/...
9037087